



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/539

Алтай хот


**“Хуурын эгшиг-2021” яруу найргийн  
наадам зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 1.1.1, 1.2.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 41 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Алтай нутгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг алдаршуулж, бахархлыг сэргээж, орон нутгийн онцлогийг илэрхийлсэн соёл урлагийн ажил үйлчилгээг бий болгох ажлын хүрээнд Мишигийн Цэдэндоржийн нэрэмжит “Хуурын эгшиг-2021” яруу найргийн наадмыг зохион байгуулахад шаардагдах 3,150,000 (гурван сая нэг зуун тавин мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Отгонбаяр)-Ддаалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР